



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/151

Эрдэнэт

### Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5 “а”, 29.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, “Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолын зургаадугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан дэд хөтөлбөрүүдийг боловсруулахад шаардагдах 40.000.000 /Дөчин сая / төгрөгийг 2017 онд зарцуулах төсөл хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын  
~~24~~ ны өдрийн ~~1/5~~ дугаар захирамжийн хавсралт

ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ БОЛОВСРУУЛАХАД  
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/Д	Зардлын төрөл	Дүн /мян.төг/
1	Ахмад настныг дэмжих "Ач санах" дэд хөтөлбөр, анхдагч илгээлтийн эздийн "Анхдагч" дэд хөтөлбөрүүдийг боловсруулах	20.000.000
2	"Багш" дэд хөтөлбөр боловсруулж батлуулах	20.000.000